

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт

НЭГ. Удирдлага зохион байгуулалт

ХОЁР. Санхүүгийн тайлангийн аудит

ГУРАВ. Гүйцэтгэлийн аудит

- Нэгдсэн удирдамжаар хийсэн гүйцэтгэлийн аудит
- Өөрийн санаачилгаар хийсэн гүйцэтгэлийн аудит

ДӨРӨВ. Нийцлийн аудит

ТАВ. Дотоод ажил

- 5.1 Хэрэгжүүлсэн ажил
- 5.2 Мэргэжлийн тасралтгүй сургалт
- 5.3 Мэдээлэл технологийн ажил
- 5.4 Хүний нөөц
- 5.5 Архив, албан хэрэг хөтлөлт

ЗУРГАА. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

ДОЛОО. Дүгнэлт санал

Товчилсон үгийн жагсаалт

- **ҮАГ** - Үндэсний Аудитын Газар
- **МУЕА** - Монгол Улсын Ерөнхий аудитор
- **УИХ** - Улсын Их Хурал
- **ИТХ** - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- **ТАБ** - Төрийн аудитын байгууллага
- **ГХБХБГ** - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
- **ГАГ** - Гүйцэтгэлийн аудитын газар
- **НДШ** – Нийгмийн даатгалын шимтгэл
- **ОНӨААТҮГ** - Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
- **ТЕЗ** - Төсвийн ерөнхийлөн захирагч
- **ТТЗ** - Төсвийн төвлөрүүлэн захирагч
- **ЕБС** - Ерөнхий боловсролын сургууль
- **ЗДТГ** - Засаг даргын Тамгын газар
- **ХАК** - Хувийн Аудитын Компани
- **ТББ** - Төрийн бус байгууллага
- **УТХО** - Улсын төсвийн хөрөнгө оруулалт
- **ОНХС** - Орон нутгийн хөгжлийн сан
- **ОНХО** - Орон нутгийн хөрөнгө оруулалт
- **ОНТ** – Орон нутгийн төсөв
- **ТБОНӨХБАҮХА** - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
- **СХС** - Сум хөгжүүлэх сан
- **ШШГГ** - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
- **ШШГХ** – Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан ТАБ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 59 ажлыг гүйцэтгэхээр боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Тамгын дарга Ц.Ганболд нараар батлуулан, мөрдөж ажиллаа.

Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр гаргаж, Үндэсний аудитын газарт хүргүүлээ.

Албан хаагчид байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, дарга тэргүүлэх аудитораар батлуулж, улирал бүр биелэлтийг гарган, ажлаа дүгнүүлээ.

Тайлант хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг биелүүлэхэд батлагдсан 12 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, өөрийн байгууллагын 10 ажилтан, 2 хараат бус хувийн аудитын компанийн 6 ажилтан нийт 16 хүн, давхардсан тоогоор 954 өдөр ажиллаж, 199 байгууллагын санхүүгийн тайланд **санхүүгийн аудит** хийж, **гүйцэтгэлийн аудит** нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр 1, өөрийн санаачилгаар 2, нийт 3 аудитыг хийж гүйцэтгэлээ. Хувийн аудитын 2 компанитай гэрээ байгуулан орон нутгийн төсөвт 99 байгууллагын санхүүгийн тайланд баталгаажуулах аудитыг хийлгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд 1 гэрээт ажилтныг 3 сарын хугацаагаар авч ажиллуулсан нь аудитын ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхэд үр дүнгээ өглөө.

Тайлант хугацаанд 13666.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 7 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэн тухайн байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж, тухайн онд 2634.2 сая төгрөгийн үр өгөөжийг тооцож, нийт 145.4 сая төгрөгийн зөрчилд 50 акт тогтоож 102.9 сая төгрөгийн актын төлбөрийг барагдуулж, үүнээс орон нутгийн төсөвт 93.0 сая төгрөгийг төвлөрүүлж, 1812.2 сая төгрөгийн зөрчилд 39 албан шаардлага хүргүүлснээс 693.0 сая төгрөгийн 24 албан шаардлага заасан хугацаанд хэрэгжиж, 1033.1 сая төгрөгийн 7 албан шаардлагын хэрэгжүүлэх хугацаа болоогүй, 86.1 сая төгрөгийн 8 албан шаардлага биелээгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дах заалтыг үндэслэн хариуцлага тооцуулах 10 албан шаардлагыг хүргүүлж, 9 албан тушаалтанд хариуцлага тооцуулан, 1 албан шаардлагын хугацаа болоогүй байна.

Тайлант онд хууль хяналтын байгууллагад 992.9 сая төгрөгийн 269 асуудлыг шилжүүлэн хянагдаж байна. Үүнээс 985.0 сая төгрөгийн 268 асуудал нь сумдын сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал болно.

Тайлант хугацаанд 2634.2 сая төгрөгийн үр өгөөжийг тооцож ажилласнаар, төсвийн зарцуулалтын хүлээгдэж буй гүйцэтгэлийн 240.8 сая төгрөгийн зардалд харьцуулахад нэг төгрөгийн зардалд 10.9 сая төгрөгийн үр өгөөж ноогдож байна.

ХОЁР. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрөөр 1, өөрийн санаачилгаар 2 нийт 3 гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- I. Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг
- II. Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжин хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн, үр ашиг
- III. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон зээлийн зарцуулалт, үр дүн

3.1. Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө



Аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон тухайн салбарын үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, барилга, байгууламжийн чанар, насжилт, хүчин чадал зэргийг тооцон үзэж хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөж байх шаардлагатай байна.

Цэцэрлэгийн хувьд:


2020 оны байдлаар төрийн өмчийн 38 цэцэрлэгийн нийт суурилагдсан хүчин чадал 3155 хүүхэд хүлээн авах боломжтой. Харин цэцэрлэгт хамрагдахаар бүртгүүлсэн нийт хүүхдийн тоо 4776 ба цэцэрлэгүүдийн нийт ачаалал 51,3%-ийн хэтрэлттэй байна.

График 1: Цэцэрлэгийн ачаалал

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан




Тухайлбал Улиастай сумын 9 цэцэрлэг 890 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай боловч цэцэрлэгт нийт 1750 хүүхэд хамрагдаж, ачаалал хэтрэлт 50,8% байгаа нь бусад сумдтай харьцуулахад хамгийн өндөр байна.



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан


Аймгийн хэмжээнд 6-18 хүртэлх насны нийт 17981 хүүхэд байна. Үйл ажиллагаа явуулж буй 29 төрийн өмчийн сургуулийн нийт суурилагдсан хүчин чадал 13030 хүүхэд хүлээн авах боломжтой боловч 15535 хүүхэд сургуульд хамрагдсан буюу сургуулийн ачаалал 2505 хүүхдээр хэтэрсэн байна.

График 2



Сургуулийн барилгуудын хувьд насжилт өндөр байгаа хэдий ч Асгат, Алдархаан, Баянхайрхан, Дөрвөлжин, Завханмандал, Яруу, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Ургамал, Түдэвтэй, Сантмаргаз зэрэг суманд хүчин чадалдаа хүрч ажиллаж чадахгүй байгаа нь сургуулийн барилгын хэрэгцээ шаардлага харьцангуй бага гэж дүгнэхэд хүргэж байна.

Зураглал 2 Ашиглалт



Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 2 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулжээ.

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан



1. Хар нуур орчмын аялал жуулчлалын дэд бүтэц төсөл /Завхан, Улиастай сум/

1-р багц Улаагчны хар нуур, Ногоон нуурын байгалийн цогцолборт газрууд болон Отгонтэнгэрийн дархан цаазат газрын тусгай хамгаалалттай бүсэд экосистемийн судалгаа хийх ажил хийгдсэн байгаа боловч шаардлагын хэмжээнд хүрэхгүй байв.



2. Хар нуур орчмын аялал жуулчлалын дэд бүтэц төсөл /Завхан, Улиастай сум/

8-р багц “Завхан аймгийн аялал жуулчлалын веб сайт, аппликэйшн” хийнэ гэсэн ажил хийгдэж комисс хүлээж авсан боловч аудитын явцад тус веб сайт, аппликэйшн ажиллаагүй бөгөөд хэрэгжилт маш хангалтгүй байлаа. /Албан шаардлага хүргүүлсэн/



Б.2.1. Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 73 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжжээ.

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны тайлан



Нийт санхүүжилтийг дараахь байдлаар зарцуулахаар хуваарилжээ.



41 төсөл арга хэмжээнээс/ багц задгайнаар/ 31 төсөл арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжиж 10 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй гэрээ сунгасан байна.

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Олгос он санхүүжилт	Гэрээ сунгасан шалтгаан
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан, Эрдэнэхайрхан сум	1790.0	1790.0	1465.2	/Ковид-19 цар тахлын улмаас материал татан авалт болон ажиллах хүчний орох гарах хөдөлгөөн хаагдаж ажил гүйцэтгэх боломжгүй болсон
2	Баазын район, ХААУДУГ, 8 дугаар цэцэрлэг, 9 дүгээр цэцэрлэгийн усан хангамж, ариутгах татуургын угсралтын ажил, багуудын бохирын болон дулааны шугам сүлжээ /Завхан, Улиастай сум/ 2-р багц Богдын гол багийн Бор дүнзэн барйны гадна бохир усны шугам 90 м-ажил	85.0	85.0	45.6	Ган ХХК шалгарсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй тул гэрээг цуцалж Товцог бурхант ХХК-тай гэрээ байгуулсан. Газар хөлдөж шугам татах боломжгүй болсон тул технологийн зогсолт хийж
3	Баазын район, ХААУДУГ, 8 дугаар цэцэрлэг, 9 дүгээр цэцэрлэгийн усан хангамж, ариутгах татуургын угсралтын ажил, багуудын бохирын болон дулааны шугам сүлжээ /Завхан, Улиастай сум/ 3-р багц Товцог багийн гадна бохирын шугамын ажил 250 м-ажил	300.0	299.9	101.7	Ковид-19 цар тахлын улмаас материал татан авалт болон ажиллах хүчний орох гарах хөдөлгөөн хаагдаж ажил гүйцэтгэх боломжгүй болж
4					Сумын төвийн шинэчлэлийн ажил нь 2020 оны 11 сарын 30-ны өдөр ашиглалтад орох байсан боловч цэцэрлэгт хүрээлэнгийн төлөвлөлтөнд орсон 6 айлын нүүлгэн шилжүүлэлт хийгдээгүй Тус сум нь нэгдсэн дулаанаар хангах ажлыг Ган-Доной ХХК хийлгэж гүйцэтгүүлэн нийлүүлтийг

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан

	Ø Сумын төвийн шинэчлэл /Завхан, Алдархаан сум/	4900.0	4885.0	4272.4	хийдэг,гэтэл уг төсөлд шинээр уурын зуухны барилга тусгагдаж баригдаж байгаа нь цаашид уг барилга ямар зориулалтаар ашиглагдах эсэх нь тодорхойгүй байдлыг бий болж байна. Мөн тус төслийн зураг төсөвт усан сан, цэвэрлэх байгууламж, уурын зуухны цахилгааны эх үүсвэр тусгагдаагүй байсан тул дахин техникийн нөхцөл гаргуулж зураг төсвийг хийлгүүлсэн нь ажил удааширах нэг шалтгаан болж байна.
5	Цэвэр усны худаг, усан сан, халуун ус, нийтийн спортын талбай /Завхан, Улиастай, Сантмаргац сум/ 1-р багц Өлзийт Товцог Чигэстэй багт халуун усны барилга барих /4 душ, 1 саун/	195.0	187.4	162.7	Халуун усны барилгуудын ажил дуусч техникийн комисс ажиллуулах хүсэлт ирүүлсэн боловч ковид-19 цар тахлын улмаас хол хорионд орж комисс ажиллуулах боломжгүй болсон.
6	Цэвэр усны худаг, усан сан, халуун ус, нийтийн спортын талбай /Завхан, Улиастай, Сантмаргац сум/ 3-р багц Улиастай сумын Жинст, Богдын гол багт тоглоомын талбай байгуулах	133.2	127.6	111.0	Техникийн комисс ажиллуулах хүсэлт ирүүлсэн боловч ковид-19 цар тахлын улмаас хол хорионд орж комисс ажиллуулах боломжгүй болсон.
7	Цэвэр усны худаг, усан сан, халуун ус, нийтийн спортын талбай /Завхан, Улиастай, Сантмаргац сум/ 5-р багц Улиастай сумын Чигэстэй, Жаргалант багт тоглоомын талбай байгуулах-	133.2	127.6	111	Техникийн комисс ажиллуулах хүсэлт ирүүлсэн боловч ковид-19 цар тахлын улмаас хол хорионд орж комисс ажиллуулах боломжгүй болсон.
8	Цэвэр усны худаг, усан сан, халуун ус, нийтийн спортын талбай /Завхан, Улиастай, Сантмаргац сум/ 7-р багц Сантмаргац сумын халуун ус барих	65.4	65.4	62.7	Гадна дотор заслын ажил хийгдсэн. Бохирын цооног хийгдэж байсан боловч хөрсний ус гарч цооног хийх боломжгүй нөхцөл үүссэн. 2021 оны хавар хийх хүсэлт ирүүлж гэрээг сунгах хүсэлт ирүүлсэн.
9	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3 км /Завхан, Их-Уул сум/-	2000.0	1998.2	1783.6	зун хур бороо ихтэй байсан тухайлбал 6-р сарын 10-аас 9-р сарын 10 хүртэл 90 хоногийн 60%-д бороотой байсан, 2 удаа үер бууж далан эвдэрч хугацаа алдсан.
10	Рашаант багаас хожуулын голын рашаан хүртэлх 35 км 10 квт-ын ЦДАШ, дэд станцын өргөтгөл /-Завхан Тосонцэнгэл сум/-ЦДАШ-ын ажил	500.0	500.0	480.3	Уг ажил нь 500.000.000 /таван зуун сая/ төгрөгийн төсөвт өртөгтэйгээр зураг төсөвгүй улсын төсвөөр батлагдаж орон нутагт эрх шилжиж ирсэн байна. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй худалдан авах ажиллагаа 2 удаа зохион байгуулахад нэг ч компани тендер ирүүлээгүй тул үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу ТЕЗ нь “Энх-өргөө” ХХК-тай шууд гэрээ байгуулжээ. Гэвч эрчим хүчний шугам татах газрын хөрс нь цэвдэгтэй, зарим газраа намаг ихтэй зэрэг шалтгаануудын улмаас батлагдсан төсөвтөө ажил хийгдэх боломжгүй байдал үүссэнээс Эрчим хүчний хөгжлийн төвөөр зураг төсөл, төсөвт магадлал хийлгэхэд төсөвт өртөг нь 875.088.502 /найман зуун далан таван сая наян найман мянга таван зуун хоёр/ төгрөг болж нэмэгдэж нэмэлт төсөв 357,0 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай болж гэрээний хугацаанд ашиглалтад орох боломжгүй болжээ


Ашиглалтад орсон зарим төсөл арга хэмжээнээс дурьдвал.

1. Дөрвөлжин сумын ЭМТ-ийн барилгын их засварын ажил.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нэршил Их засвар гэдгээр ирсэн ч сумын иргэдийн болон сумын ЭМТ-ийн ажилтнуудын саналаар 9.6*12.4 хэмжээтэй 2 давхар Канад технологийн өргөтгөлийн барилга болж баригдсан байна.


Зураг 5. Дөрвөлжин сумын ЭМТ

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны тайлан



Хэдийгээр засврыг зориулалтын дагуу өөрчлөж уг барилгыг барьсан боловч захиалагчийн зүгээс хаалга амалгаа бэхэлгээ муу, крант гоожуурын суурь бэхэлгээ муу, шалны дуу чимээ их, дуу тусгаарлалт муу гэсэн тайлбарыг өглөө. Барилгын чанарын асуудлыг газар дээр үзэх байсан ч хатуу хөл хорио давагдашгүй хүчин зүйлээс болж бодит аудитыг хийж чадсангүй.

2. Тэс сумын ЕБС-ийн их засвар



**Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны тайлан**



Хугацаанд чанартай хийж гүйцэтгэсэн, хэрэглэгч талаас элдэв санал гомдол гараагүй болно.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмж хууль, эрх зүйн баримт бичигт туссаны дагуу хэрэглэгчидэд нийлүүлэгдсэн ч бүрэн хүрч чадаагүй байна.

2020 онд Сангийн, ХНХ, ЭМ, БШУЯамдуудаас нийт 1754.15 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сурах бичиг нийлүүлэгдсэн байна.

Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж					сая төгрөгөөр/		
д/д	Яам	Хаана	Нийлүүлэх	Нийлүүлсэн	Зөрүү /дутуу		Бүртгэлд тусгасан эсэх
			Үнийн дүн	Үнийн дүн	тоо/ш	үнийн дүн	
1	СЯ		149.3	149.3	2	1.28	тийм
2	СЯ	Тосонцэнгэл сумын Соёлын төв	60.0	30.6	23	29.4	тийм
3	ХНХЯ	Халамж үйлчилгээний газар	20.0	17.99			тийм
4	ЭМЯ	Их-уул сумын ЭМТ	18.9	18.9			тийм
5	ЭМЯ	Тосонцэнгэл сумын ЭМТ	110.8	110.8			тийм
6	ЭМЯ	Завхан Нэгдсэн эмнэлэг	200.9	199.5	1	1.47	тийм
7	БШУЯ	За. ЕБС, Цэцэрлэгүүд	640.5	640.5			тийм
8	БШУЯ	За. ЕБС, Цэцэрлэгүүдэд сурах бичиг	78.02				үгүй
9	Хөдөлмөр эрхдэтийг дэмжих төсөл	За. ЕБС,	475.73				үгүй
		дүн	1754.15	1167.59	26	32.15	

Аудитын явцад тус яамдаас нийлүүлэгдсэн байгууллагуудын нягтлан бодогч, няравуудтай тулган баталгаажуулахад 1167.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгасан байсан ба 553.7 сая төгрөгийн хөрөнгө, сурах бичгийг бүртгэлд тусгаагүй, 32.15 сая төгрөгийн хөрөнгө нийлүүлэгдээгүй байхад бүртгэлд тусгасан

Дүгнэлт хийхэд БШУЯ болон бусад төсөл хөтөлбөрүүдээс нийлүүлэгдэж байгаа тоног төхөөрөмж, сурах бичгийг бүртгэлд тусгасан эсэх, ашиглалтыг нягтлаж үзэх

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны тайлан

шат шатны мэргэжлийн байгууллагуудын хяналт, шахалт суларсан, удирдлага болон бүртгэлийн ажилтнууд жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахдаа харьяалагдах яам, боловсрол соёлын газар, бусад байгууллагуудтай хөрөнгийн тооцоо нийлдэггүй дутагдал хавтгайрсан байна гэж үзлээ.

Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан.

Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 41 төсөл арга хэмжээнд 2020 онд олгох 15,311.4 сая төгрөгийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж 5 ажлын 459,5 сая өгрөгийн санхүүжилтийг /100090051350/ тоот барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Мөн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийг барьцаа чөлөөлөх хугацаанд нь чөлөөлдөггүй, төсөл арга хэмжээ дуусч улсын комисс хүлээж авч акт үйлдсэн байхад гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг бүрэн олгодоггүй ямар нэгэн ажлын дутуу үүрэг даалгавар барьцаа болгон үлдээх зөрчил илэрч байна.

Тухайлбал: Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн барилга 2019 онд дуус ашиглалтанд орсон байхад үлдэгдэл санхүүжилтээс 5118,4 сая төгрөгийг одоо болтол олгоогүй, “Хар нуур орчмын аялал жуулчлалын дэд бүтэц төсөл”-ийн багцад хийгдсэн Отгон сумын Халтар, Чулуутын голын гүүрийн ажил дуусан хүлээж авсан байхад 34379,7 сая төгрөгийг олгоогүйгээс 5803,8 сая төгрөгийг УАГ-ын дахин хяналтаар төлбөрийн акт тогтоогдож Улсын төсвийн дансанд татагдаж байна.

2020 оны эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцтгэлийн аудитын хугацаанд давагдашгүй хүчин зүйл “Ковид-19 цар тахлын улмаас Завхан аймагт 2021 оны 04 сарын 11-ээс 2021 оны 05 дугаар сарын 08 өдрийг дуустал аймгийн Онцгой комиссын шидэврээр хатуу хөл хорионд байгаа тул дуусан хөрөнгө оруулалтын ажлуудыг газар дээр нь үзэх боломжгүй байснаас эрсдэл бүхий асуудалд чиглэсэн аудитаар дараахь төсөл арга хэмжээнүүдийг үзэхээр шийдвэрлэв.


/сая, төг-

р/

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжилтийн дүн
1	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Завхан аймгийн хар нуур орчмын аялал жуулчлалын дэд бүтэц төслийн 4-р багц болох Отгон сумын халтар, чулуутын голын модон гүүрийн засвар шинэчлэл	280.9
2	Завхан аймгийн хар нуур орчмын аялал жуулчлалын дэд бүтэц төслийн 6-р багц Идэр сумаас ногоон нуур хүртэлх 22 км авто зам, гүүрийн засвар	300.0
3	Завхан аймгийн хар нуур орчмын аялал жуулчлалын дэд бүтэц төслийн 7-р багц Доной цэцэрлэгт хүрээлэн болон аялал жуулчлалын мэдээллийн төв барих ажил	386.0

Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 73 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжжээ.

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан



Гүйцэтгэлийн аудитаар өгсөн 2 албан шаардлага бүрэн хэрэгжиж 30,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн бөгөөд 1 албан шаардлага, зөвлөмж хэрэгжих

шатандаа хугацаа болоогүй, 6,980,3 сая төгрөгийн үр өгөөжийн хүлээн зөвшөөрч бүртгэлд тусган албан тоотыг ирүүлсэн байна.

Нэгдсэн дүгнэлт: Нэгдсэн удирдамжаар хийгдсэн 1, өөрийн санаачилгаар 2, нийт 3 гүйцэтгэлийн аудитыг 6 албан хаагч 170 өдөр ажиллаж, аудитад .. байгууллага хамрагдлаа. Аудитаар нийт 70 төрлийн 4803.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 7 байгууллагад 25.7 сая төгрөгийн албан шаардлага, 4729.8 сая төгрөгийн зөрчилд 46 заалт бүхий зөвлөмж хүргүүлж, 47.9 сая төгрөгийн зөрчилд 16 төлбөрийн акт тогтоож, 15 актын 44.0 сая төгрөгийн төлбөр барагдаж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь хангуулан ажиллаа. Мөн 42 төрлийн 6357.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэж, холбогдох байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

ДӨРӨВ. НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР

ТАВ. ДОТООД АЖЛЫН ТАЛААР

5.1 Хэрэгжүүлсэн ажил

Төрийн аудитын байгууллагаас 2021 оныг "Аудитыг цахимжуулж нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх" жил болгон зарласантай холбогдуулан шилэн данс, статистик мэдээний бүртгэл нэгтгэлийн систем ашиглалтанд орсонтой холбоотой ҮАГ-ын холбогдох газруудаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох мэдээллүүдийг шивж орууллаа.

Долоо хоног бүрийн Даваа гаригт хийдэг хамт олны шуурхайг санхүүгийн тайлангийн аудитын үеэр болон Ковид-19 цар тахлын хөл хориотой үеүдэд шаардлагатай цаг хугацаанд зарлан хийж, 2021 оны 5-р сарын 01-ээс долоо хоног бүр хийж ажлын явц, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, тухайн 7 хоногт хийх ажлаа хэлэлцэж, хурлын тэмдэглэл хөтлөн, биелэлтийг тооцож, 2021 оны эхний хагас жилд төлөвлөсөн ажлуудыг бүрэн биелүүлэн ажиллаа.

2021 оны эхний хагас жилд байгууллагын шуурхай хурлыг нийт 13 удаа, удирдлагын зөвлөлийн хурлыг 8 удаа хийж, удирдлагын зөвлөлийн хурлаар санхүү, гүйцэтгэлийн аудитын дүн, илэрсэн алдаа зөрчил болон акт, албан шаардлагууд, холбогдох бусад асуудлуудыг хэлэлцэн, тэмдэглэл хөтлөн албажууллаа.

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар СТАУС программыг бүрэн ашиглаж, аудитын үе шат бүрийн ажлын гүйцэтгэлийг хугацаанд нь 100 хувь орууллаа. Санхүүгийн аудитын газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу санхүүгийн

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны тайлан

аудитын гүйцэтгэлийн үе шатанд залилантай холбоотой эрсдэлийг тодорхойлж, горим сорилыг гүйцэтгэн ажиллаа.

Мөн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлтийг аймгийн Засаг даргад хүргүүлэн, санхүүгийн тайлангийн аудитын нэгдсэн дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргад танилцууллаа.

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийгдсэн гүйцэтгэлийн аудит, өөрийн санаачилгаар хийгдсэн аудитуудын нээлтийг байгууллагын удирдлагууд, холбогдох ажилтнуудад тухай бүр хийж, тухайн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг танилцуулан ажиллаа.

2021 оны санхүүгийн тайлангийн аудит хийх хуваарийг гарган санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалтыг А/20101 маягтаар, санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалтад үндэслэн аудит хийх хэлбэрийг байгууллага тус бүрээр санхүүгийн аудит хийх журмын 10.7-д заасан нөхцөл шаардлагын дагуу сонгож, А/30101 маягтаар нэгтгэж 2021 оны 06 сарын 09-ний дотор гаргаж, нэгдүгээр газарт хүргүүлээ.

Байгууллагын шуурхай хурал, зөвлөгөөнөөр албан хаагчдад ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилд орохгүй байх талаар сануулан, зөвлөгөө зөвлөмж өгч ажиллаж байна.

Санхүү , гүйцэтгэлийн аудитын үе шатны хяналтуудыг хэрэгжүүлэн, хууль зүйн зөвлөгөө өгч, арга зүйгээр ханган ажиллаа.

Аудитын менежер аудит бүрийн явцын ажлыг аудитын багаар 7 хоног бүрээр мэдээлэл авч, явцын чанарын хяналтыг хийж, сарын болон 14 хоногийн ажлын тайлан, дараагийн 14 хоногт хийх ажлын төлөвлөгөөг гарган хугацаанд нь Захиргаа, удирдлагын газарт хүргүүлж ажиллаа.

Төрийн аудитын байгууллагын ажилтны Ёс зүйн дүрмийн төслийг албан хаагч бүр уншиж судлан холбогдох саналаа Захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн.

“Аудитын үр өгөөжийг төлөвлөх, бүртгэх , тайлагнах, хянах, мэдээлэх журам”-ыг шинэчлэхтэй холбоотой саналаа боловсруулж заасан хугацаанд холбогдох хаягаар хүргүүлсэн.

ТАБ-ын 2020 оны эхний хагас жилийн болон жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг гарган, холбогдох нотлох баримтын хамт ХШҮДАГ-т хүргүүлсэн.

2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөтэй уялдуулан шинжээчийг аудитод оролцуулах саналыг, төсвийн тооцооллын хамт гарган Тамгын газарт хүргүүлсэн.

Аймаг, орн нутгийн хэмжээнд Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулан эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн ажиллаж байна.

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан

2020 онд өгөгдсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актыг эх хувилбараас цахим хэлбэрт (PDF) шилжүүлэн, Стратегийн удирдлагын газарт хүргүүллээ.

Дөрвөлжин сумын төсөвт байгууллагуудын 2020 оны жилийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар тус байгууллагуудад дулаан ханган нийлүүлэгч "Ган доной"ХХК нь барилга эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл болон дулааны үнэ тариф тогтоолгоогүй байгаа нь Барилгын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байж болзошгүй тул шалган шийдвэрлүүлэхээр аймгийн Прокурорын газарт хүргүүлсэн.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн иргэн хуулийн этгээдэд олгосон төслийн зээлийн хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй, төр хохирч байгаа үйлдэлд итгэмжлэлээр оролцож хохирлыг холбогдох этгээдээс төлүүлэхийг аймгийн Прокурорын газар болон Тосонцэнгэл сум дахь сум дундын прокурорын газруудад холбогдох сумдын асуудлыг тус тус шилжүүлсэн.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитын явцад 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Улиастай сумын Богдын гол багийн Цэнгэлдэх хотхоныг цэвэр, бохир, дулааны шугам сүлжээ ажлыг тендер сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулсан, экспертийн дүгнэлтээр зураг төсөв зөрчилтэй байхад гүйцэтгэсэн зэрэг нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэж өгөхийг 2021.03.31-ний 490 тоотойр Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжилсан бөгөөд Улсын ерөнхий прокурорын газарт шилжүүлээд байна.

Албан хаагчдын уншиж судалсан байх хууль, журам, зааврын жагсаалтыг гаргаж, эмхэтгэл гарган, аудитын ажилд ашиглаж байна.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн цаг үеийн судалгааг тухай бүр гарган тогтоосон хугацаанд холбогдох газруудад хүргүүлэн ажиллаа.

Тайлант оны эхний хагас жилд Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Д.Оюунжаргал "Санхүүгийн тайлангийн аудит, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн дүнгийн талаар", гүйцэтгэлийн аудитын ахлах аудитор Б.Дагвасүрэн "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын талаар тус тус мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд түгээлээ.

Нууцад хамаарах цахим мэдээллийн хамгаалалт болон биет хамгааллын чиглэлээр журамд тусгасан хамгаалалтуудыг гүйцэтгэж, аюулгүй байдлыг хангаж, хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Аудитын мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг сайжруулах зорилгоор зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг 14 хоног тутамд гаргаж, хамт олны шуурхайгаар хэлэлцэж тогтоосон хугацаанд барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Акт, албан шаардлагын хэрэгжих хугацаа дууссан байгууллагуудад төлбөр, албан шаардлагыг барагдуулахгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуульд

заасны дагуу сахилгын шийтгэл ноогдуулахыг анхааруулж албан тоотыг хүргүүлэн ажиллаж байна

"Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам"-ын дагуу хавсралтаар аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн аудитын үе шат бүрт СТА-ын ахлах аудитор, аудитын менежер, Тэргүүлэх аудитор нар үнэлгээ өгч, үнэлгээний нэгтгэсэн дүнг гаргаж, ХАК-дад хүргүүлсэн болно.

Албан хаагчдын 2020 оны ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд гаргаж, тайланг Авлигатай тэмцэх газарт тайлагнасан. Аудитын үйл ажиллагааг сонирхлын зөрчлөөс ангид хэрэгжүүлж байна.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын 2.4-т заасан тогтвортой хөгжлийн засаглалын бодлогыг байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын чанарын хяналтын тогтолцоог төлөвшүүлж, эрсдэлд суурилсан төрийн аудитыг хэрэгжүүлэх ажлыг зорилт болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.

5.2 Мэргэжлийн тасралтгүй сургалтын талаар:

Байгууллагын албан хаагчдын мэргэжлийн сургалтын хэрэгцээ шаардлагын судалгааг гаргаж, төрийн аудитын байгууллагаас 2021 онд зохион байгуулах сургалт, хөгжлийн арга хэмжээний талаарх судалгааг Стратегийн удирдлагын газрын сургалт хариуцсан менежерт хүргүүллээ.

Байгууллагын 2021 онд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөг сургалт хариуцсан ажилтан боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 онд дотоод сургалтыг 16 сэдвээр зохион байгуулахаар төлөвлөснөөс дараах сургалтуудыг зохион байгуулан ажиллаа. Үүнд:

- ✓ Санхүүгийн тайлангийн аудитын талаар Үндэсний аудитын газраас ирсэн чиглэл, заавар журмаар тус байгууллагын аудиторуд болон хувийн аудитын компанийн аудиторудад аудитын менежер Г.Хашцэцэг, Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Д.Оюунжаргал нар,
- ✓ "Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам"-ыг хамт олонд танилцуулах сургалтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн
- ✓ "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын сургалтыг аудитор Б.Жалбаа
- ✓ "ТАБ-ын дэргэдэх Ахмадын хорооны дүрэм", "Амадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг хамт олонд танилцуулах сургалтыг аудитын менежер Г.Хашцэцэг нар тус тус хийлээ.

Дээрх сургалтуудыг амжилттай зохион байгуулж баримтжуулан ажиллаа.

Үндэсний аудитын газраас зохион байгуулсан арга зүйн болон шинэчилсэн стандартуудыг ойлгох онлайн сургалтуудад албан хаагчдыг цаг тухай бүрд хамруулсан.

Төрийн аудитын байгууллагын “Удирдах ажилтны зөвлөгөөн, сургалт”-д онлайнаар Дарга бөгөөд тэргүүлэх аудитор оролцож, байгууллагын албан хаагчдад мэдээлэл хийж, зөвлөгөөнөөр өгөгдсөн сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

Дарга тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нь МУИС-д антропологийн чиглэлээр нь докторантур, Аудитор Б.Мөнхнасан, Д.Пүүжмаа нар МУИС-ийн Завхан сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр магистр, Аудитор Б.Жалбаа Үндэсний техникийн их сургуульд хууль эрх зүйн чиглэлээр магистраар тус тус суралцаж байна.

5.3 Мэдээлэл технологийн ажлын талаар

Тайлант хугацаанд Үндэсний аудитын газрын нэгдсэн цахим хуудас zavkhan.audit.mn -д санхүүгийн тайлангийн аудитын 199, гүйцэтгэлийн аудитын 1, цаг үеийн, өдөр тутмын үйл ажиллагааны мэдээлэл 15, нийт 215 мэдээ, мэдээллийг байршуулж, олон нийтэд түгээлээ.

Байгууллагын сервер, сүлжээ, компьютерын мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Үндэсний аудитын газраас цаг үеийн байдлаар зохион байгуулсан онлайн хурал, сургалтуудад техник хангамжийн бэлэн байдлыг хангаж, идэвхитэй оролцлоо.

Байгууллагын мэдээ мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх зорилгоор Завхан Төрийн аудитын газар нэртэй цахим хуудсыг нээж, цаг үеийн мэдээ, мэдээлэл болон сургалт, ярилцлага, нэвтрүүлгийг тухай бүр байршуулж байна.

5.4 Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:

2021 оны эхний хагас жилд дарга бөгөөд тэргүүлэх аудиторовын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой А тушаал 102, боловсон хүчинтэй холбоотой Б тушаал 11 гарсан байна. Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр гаргасан тушаалаас аудитын тайлан баталгаажуулах 2, акт, албан шаардлага баталгаажуулах 89 тушаал зохион байгуулалтын чиглэлээр 8, хөрөнгө зарцуулахтай холбоотой 2 тушаал байна. Мөн байгууллагад ирсэн бичиг 139, явуулсан бичиг 551 бүртгэгдэж, 14 байгууллага, 1 иргэнээс ирсэн өргөдөл хүсэлтийг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэж, хариуг хүргүүлэн ажиллаа.

Байгууллагад ирсэн бичиг, явсан бичиг, захирамжилсан баримт бичиг, өргөдөл гомдлын дэвтрийг тухай бүр хөтөлж, архивын заавар, журмыг хэрэгжүүлэн ажиллаа.

2021 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга хадгалах 39 баримт, 70 жил хадгалах 4 баримт, байгууллагын дотоод ажилтай холбоотой түр хадгалах 40

баримт, нийт 83 баримтыг үдэж цэгцлэн, архивд хүлээн авч, хадгаламжийн нэгжид бүртгэж, архивын нэгж үүсгэлээ.

Мөн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын баримт материалыг байгууллагын аудиторууд болон хувийн аудитын компанийн аудиторууд үдэж цэгцлэн, нийт 239 баримтыг архивд хүлээлгэн өгч, хадгаламжийн нэгжид бүртгэн, архивын нэгж үүсгэлээ.

Байгууллагын баримт бичгийн үнэ цэнийг нягтлан шалгах комисс баримт бичгийн хадгалах хугацааг нягтлан шалгаж, тус байгууллагад 2021 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан, хэлэлцэж, 2020 оны 70 жил хадгалах, байнга хадгалах, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг нягтлан, дарга бөгөөд тэргүүлэх аудитораар батлууллаа.

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, дүрэм журмын дагуу шуурхай зохион байгуулж, архивын баримтын данс бүртгэл үүсгэж ажиллаа. Мөн аймгийн Архивын тасагт байгууллагын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын талаарх мэдээг гаргаж, хугацаанд нь хүргүүллээ.

5.5 Хүний нөөцийн талаар:

Байгууллагын 12 албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг хангуулах ажлыг зохион байгуулж, албан хаагчдын албан тушаалын шинэчилсэн тодорхойлолт, хувь хүний намтар, ажил байдлын тодорхойлолт зэрэг баримт бичгүүдээр хувийн хэргийн баяжилтыг хийж, боловсон хүчний хувийн хэргийн бүртгэлийг шинэчиллээ.

Мөн албан хаагчдын ажилласан жилийн судалгаа, хүний нөөцтэй холбоотой цаг үеийн бусад судалгааг тухай бүр гарган, холбогдох газарт хүргүүлж ажиллаа.

Төрийн албаны зөвлөлийн “**Хүний нөөцийн систем**”-д шинээр томилогдсон 2 албан хаагчийн бүртгэлийг оруулж, байгууллагын албан хаагчдын цалин, цалингийн нэмэгдэл, бусад өөрчлөгдсөн мэдээллийг цаг тухай бүр шинэчиллээ.

Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан олон жил үрбүтээлтэй ажилласан албан хаагчдыг шагнуулах хүсэлт, холбогдох материалыг ҮАГ болон аймгийн Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүллээ.

2021 оны ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг Хөдөлмөрийн хууль, байгууллагын дотоод журамын дагуу ажилтнуудын саналыг харгалзан гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитад 1 ажилтныг гэрээгээр ажиллуулсан. Нийцлийн аудитын ахлах аудитор Ч.Бямбасүрэн УБ хот шилжиж, аудитор Г.Заяаг ахлах аудитораар, нягтлан бодогч, дотоод ажилтан Ц.Оюунсүвдыг аудитораар томилон ажиллуулахаар МҮЕА-т хүсэлт уламжлан тус тус томилогдон ажиллаж байна. Нягтлан бодогч, дотоод ажилтнаар 2021 оны 2-р сарын 1-ээс Ц.Баасанжаргалыг томилон ажиллуулж байна. 2021 онд байгууллагад 1 орон тоо нэмэгдэн батлагдаж аудитор Г.Баасанжаргалыг томилуулахаар холбогдох материалыг хүргүүллээ. Албан хаагчдын бүртгэл мэдээлийн санг бүрдүүлэн ажиллаж байна.

ЗУРГАА. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2021 онд 477.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилд 240.8 сая төгрөгийн орлого санхүүжилттэй үйл ажиллагаа явуулж, батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомж, заавар, журам, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж ажиллаа.

Батлагдсан төсвөөс бичиг хэргийн зардал 641.6 мянган төгрөг, шуудан, холбоо, интернэтийн зардал 128.0 мянган төгрөг дутуу санхүүжигдэж, нийт 769.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт зардлыг зардлын зүйлийн эзлэх хувиар авч үзвэл: Цалингийн зардал 62.3 хувь, ажил олгогчоос төлөх НДШ 5.7 хувь, тавилга худалдан авсан зардал 2.8 хувь, албан томилолтын зардал 0.9 хувь, бичиг хэргийн зардал 0,4хувь, тээвэр шатахууны зардал 10 хувь, ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал 0.2 хувь, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал 3.2 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 14,5 хувийг тус тус эзэлж байна.

Байгууллагын албан хаагчдын цалингийн тооцооллыг сар бүр хийж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл ахих 2 албан хаагчийн нэмэгдлийг тушаалаар баталгаажуулан олголоо.

Мөн ковид-19 цар тахлыг дотооддоо алдсантай холбоотой албан хаагчдыг гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор интернэтийн суурь хураамжийн төлбөрт 200.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тайлагнаж, “Мишээл-Од Аудит” ХХК-аар баталгаажуулан, “Зөрчилгүй” санал дүгнэлт авч, санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар өгөгдсөн 4 заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлэн, хариуг хугацаанд нь албан тоот, нотлох баримтын хамт хүргүүллээ.

Мөн жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн яамны төсөвт байгууллагын Э-тайланд оруулж, Төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүллээ.

Төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, Үндэсний аудитын газрын Захиргаа удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлэн, нэгтгүүлж байна. Мөн төсвийн шууд захирагчийн 2021 оны хагас жилийн санхүүгийн тайланг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлэхээр бэлтгэж байна.

Нийгмийн даатгалын тайланг сар бүр, татварын тайланг улирал бүр онлайн программаар гарган, холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж, баталгаажуулан, өглөг авлагагүй ажиллаа.

“Шилэн дансны тухай” хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангах ажлын хүрээнд байгууллагын төсвийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, зарцуулалт болон төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг сар бүр

хуулийн хугацаанд www.shilendans.gov.mn сайтад байршуулан мэдээлж, улирал бүр холбогдох дээд шатны байгууллагад илгээж, мэдээ тайлангийн хоцрогдолгүй ажиллаа.

Байгууллагын эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг дарга, тэргүүлэх аудиторов А/102 дугаар тушаалаар байгуулж, ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, байгууллагын эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавин, хагас жилийн тооллогын дүн, байгууллагад хэрэгцээ шаардлагатай хөрөнгийн талаар тухай бүр дүгнэлт гарган ажиллаж байна.

Батлагдсан санхүүжилтийн хэмжээнд санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын ажлаар аймгийн 9 суманд ажилласан аудитор, үйлчилгээний ажилтны албан томилолт, шатахууны зардлыг тухай бүр бүрэн санхүүжүүлж 1245.5 мянган төгрөгийг зарцуулж, аудитыг цаг хугацаанд нь шуурхай гүйцэтгүүллээ.

Төсвийн шууд захирагчийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын болон төсвийн төслийн саналыг хугацаанд нь боловсруулж, захиргаа удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүллээ.

Байгууллагын 2021 оны төсвийн сар, улирлын хуваарь, төсвийн гүйцэтгэлийн мэдээг ил тод мэдээллийн самбарт тогтмол байршуулан, мэдээлж байна.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан ТАБ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 59 ажлыг гүйцэтгэхээр боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Тамгын дарга Ц.Ганболд нараар батлуулан, эхний хагас жилд гүйцэтгэх ажлуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаа.

Хагас жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг биелүүлэхэд батлагдсан 12 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, өөрийн байгууллагын 10 ажилтан, хувийн аудитын компанийн 6 ажилтан нийт 16 хүн, давхардсан тоогоор 954 өдөр ажиллаж, 199 байгууллагын санхүүгийн тайланд **санхүүгийн аудит** хийж, **гүйцэтгэлийн аудит** нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр 1, өөрийн санаачилгаар 2, нийт 3 аудитыг хийж гүйцэтгэлээ. Хувийн аудитын 2 компанитай гэрээ байгуулан орон нутгийн төсөвт 99 байгууллагын санхүүгийн тайланд баталгаажуулах аудитыг хийлгэлээ.

Тайлант хугацаанд ...сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, санхүүгийн бус 4 үр өгөөжийг бүртгэн тухайн байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж, тайлант хугацаанд ...сая төгрөгийн үр өгөөжийг тооцож, нийт ...сая төгрөгийн зөрчилд 48 акт тогтоож ...сая төгрөгийн актын төлбөрийг барагдуулж, үүнээс орон нутгийн төсөвт ...сая төгрөгийг төвлөрүүлж, ...сая төгрөгийн зөрчилд 45 албан шаардлага хүргүүлснээс ...сая төгрөгийн ...албан шаардлага заасан хугацаанд хэрэгжиж, 1064.3 сая төгрөгийн 8

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны тайлан

албан шаардлагын хэрэгжүүлэх хугацаа болоогүй, 40.9 сая төгрөгийн 7 албан шаардлага биелээгүй байна.

Биелээгүй албан шаардлага нь СТА-аар ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр ажиллаагүй хугацааны цалинг байгууллагын төсвөөс нөхөн олгосон 7 байгууллагын асуудлыг Захиргааны ерөнхий хуулийн 103.1 “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2 “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэсэн заалтуудын дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд өгсөн албан шаардлагын хэрэгжилт биелээгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн /шинэчилсэн/ 42 дугаар зүйлийн 42.3 дах заалтыг үндэслэн хариуцлага тооцуулах ... албан шаардлагыг тус тус хүргүүлж, ...албан тушаалтанд хариуцлага тооцуулан, 1 албан шаардлагын хугацаа болоогүй байна.

Тайлант онд хууль хяналтын байгууллагад 64.3 сая төгрөгийн 9 асуудлыг шилжүүлснээс 1.5 сая төгрөгийн 1 асуудал шийдвэрлэгдэж, 62.8 сая төгрөгийн 8 асуудал хянагдаж байна.

Тайлант хугацаанд ...сая төгрөгийн үр өгөөжийг тооцож ажилласнаар, төсвийн зарцуулалтын хүлээгдэж буй гүйцэтгэлийн ... сая төгрөгийн зардалд харьцуулахад нэг төгрөгийн зардалд ...сая төгрөгийн үр өгөөж ноогдож байна.

Тайлант онд өөрсдийн санаачилгаар дээр дурдсан үндсэн 5 ажлыг хэрэгжүүлэн ажиллаа.

Эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан болон цаашид хэрэгжүүлэх асуудлын талаар дараах саналыг ҮАГ-ын удирдлагуудад уламжилж байна.

- 1) Байгууллагын албан хаагчдын албан хэрэгцээнд шаардлагатай сүлжээний 2 олон үйлдэлт хэвлэгчийг хүсэлтийн дагуу шийдвэрлэж өгөхөд анхаарах.
- 2) Өмнөх онд хүсэлт явуулсан 1 аудиторын орон сууцны хөнгөлөлтийн асуудал шийдэгдээгүй тул тус асуудлыг шийдвэрлэж өгөх.
- 3) Цаашид байгууллага хараат бус байдлыг хангах зорилгоор аймгийн ЗДТГ-ын байрнаас өөр бие даасан байртай болох асуудлыг шийдвэрлэх

Завхан Төрийн Аудитын Газар